



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.09.24 № 183
танай _____ ны № _____ т

РАШААНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.ЧҮЛТЭМСҮРЭН ТАНАА

Төрийн аудитын газраас танай байгууллагын 2022 оны санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийсэн дүгнэлт, тайланг хүргүүлж байна.

Аудитаар 31,405.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгч ажиллалаа.

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор бүрэн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана уу.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР ~~_____~~ Б.ЭРДЭНЭ



006030179



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Рашаант сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/32/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn</p> <p>Булган аймаг 2023 он</p>	<p>Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 7034-2716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Цэрэнлхам Утас: 7034-2495 Цахим хаяг: Tserenlhamg@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Төлбөрийн акт	16
Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.....	16
5.2 Албан шаардлага	16
5.3 Зөвлөмж.....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.24 № 182

танай _____ ны № _____ т

РАШААНТ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.ЧҮЛТЭМСҮРЭН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Рашаант сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Рашаант сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Түшээт булаг ХХК-иас шатахууныг бичгээр худалдан авалт хийдэг гэх боловч и-баримтаар баталгаажуулаагүй, зарлагын баримт байхгүй, шатахуун зарцуулалтад жолоочийн тооцооны хуудас бодоогүй, ажил гүйцэтгэх гэрээ байхгүй 31,405.5 мянган төгрөгийг зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 " Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил үйлгээг, бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ыг баримтлаагүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Засаг дарга сумын Засаг даргатай байгуулсан гэрээг 94.4 хувьтай дүгнүүлэн гүйцэтгэлийн үнэлгээгээр бусад сумдаа хошуучлан гутгаар байр эзэлсэн байна.

Аудитын гол асуудал

006020214

Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдсэн хөрөнгө оруулалтын 15 нэр төрлийн 4,555.0 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг бараа материалын тайланд бүртгэж тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	39,566,424.72	55,624,831.52
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,668,400.00	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,668,400.00	-
3121	Төгрөг	2,668,400.00	-
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	2,668,400.00	-
33	АВЛАГА	-	1,447,566.80
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	247,566.80
335	Бусад авлага	-	1,200,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	1,200,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	36,898,024.72	54,177,264.72
354	Хангамжийн материал	36,898,024.72	54,177,264.72
35410	Бичиг хэргийн материал	127,600.00	127,600.00
35420	Аж ахуйн материал	36,770,424.72	54,049,664.72
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,582,771,125.15	1,776,002,023.42
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,582,771,125.15	1,776,002,023.42
392	Биет хөрөнгө	1,571,135,125.15	1,761,663,523.42
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,502,163,457.97	1,537,163,457.97
39202	Хуримтлагдсан элэгдэл	(370,944,318.30)	(424,025,564.90)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	242,377,048.00	200,678,049.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(196,869,628.52)	(117,627,631.88)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	228,775,142.40	226,315,799.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(144,523,286.19)	(71,579,403.70)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,493,877.97	23,272,086.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,686,584.34)	(7,983,330.38)
39214	Бусад үндсэн хөрөнгө	517,120,568.50	645,921,892.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	(218,771,152.34)	(250,471,830.89)
393	Биет бус хөрөнгө	11,636,000.00	14,338,500.00
39301	Программ хангамж	2,850,000.00	2,850,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,800,000.00)	(2,587,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	10,586,000.00	14,076,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,622,337,549.87	1,831,626,854.94
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	297,963.01	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	297,963.01	-
413	Өглөг	297,963.01	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	297,963.01	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,622,039,586.86	1,831,626,854.94
51	Засгийн газрын хувь оролцоо	1,622,039,586.86	1,831,626,854.94
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	467,647,997.17	467,647,997.17
51101	Өмч:- төрийн	467,647,997.17	467,647,997.17
512	Хуримтлагдсан үр дүн	269,614,812.43	479,202,080.51
51210	Өмнөх үеийн үр дүн	350,683,471.35	269,614,812.43
51220	Тайлант үеийн үр дүн	(81,068,658.92)	209,587,268.08
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	884,776,777.26	884,776,777.26
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,622,337,549.87	1,831,626,854.94

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	602,367,888.00	900,215,622.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	69,815,000.00	284,592,202.50
120	Нийтлэг татварын бус орлого	69,815,000.00	284,592,202.50
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	69,815,000.00	284,592,202.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,060,000.00	19,419,130.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	68,755,000.00	265,173,072.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	532,552,888.00	615,623,420.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	51,590,188.00	27,408,120.00
131103	ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,848,400.00	4,915,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,741,788.00	22,492,720.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	480,962,700.00	588,215,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	480,962,700.00	588,215,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	681,995,902.14	690,628,354.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	681,995,902.14	690,628,354.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	662,819,053.14	667,133,237.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	233,626,906.00	249,385,884.78
210101	Үндсэн цалин	152,447,137.00	191,913,863.04
210102	Нэмэгдэл	42,163,092.00	44,330,620.74
210105	Гэрээт ажлын хөлс	39,016,677.00	13,141,401.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,845,629.00	30,102,770.07
210201	Тэтгэврийн даатгал	20,671,723.44	20,427,781.24
210202	Тэтгэмжийн даатгал	2,127,740.80	2,468,139.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,702,191.70	1,982,597.28
210204	Ажилгүйдлийн даатгал	425,548.10	487,341.20
210205	Эрүүл мэндийн даатгал	4,918,424.96	4,736,910.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	93,589,900.00	99,734,400.30
210301	Гэрэл, цахилгаан	16,621,900.00	22,766,400.30
210302	Түлш, халаалт	76,368,000.00	76,368,000.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,262,028.00	33,421,799.73
210401	Бичиг хэрэг	2,333,500.00	3,098,000.00
210402	Тээвэр, шатахуун	15,195,708.00	22,487,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,530,000.00	2,426,999.73
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,770,000.00	4,715,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	693,500.00
210408	Бараа материал акталсны зардал	432,820.00	-
2105	Нормативт зардал	500,000.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,796,900.00	41,426,460.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	573,200.00	-
210604	Урсгал засвар	23,223,700.00	41,426,460.00
2107	Томилолт, зочны зардал	2,582,000.00	4,849,400.00
210702	Дотоод албан томилолт	2,582,000.00	4,849,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	735,500.00	735,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	374,400.00	374,400.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	361,100.00	361,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	253,880,190.14	206,677,022.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	82,172,288.00	74,530,548.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	900,000.00	1,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	170,807,902.14	131,146,474.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,176,849.00	23,495,117.31
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	2,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	20,995,117.31
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	20,995,117.31
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	19,176,849.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,176,849.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(79,628,014.14)	209,587,268.08
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,440,644.78	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,440,644.78	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,440,644.78)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(81,068,658.92)	209,587,268.08

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	533,612,888.00	633,842,550.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,060,000.00	18,219,130.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,060,000.00	18,219,130.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,060,000.00	18,219,130.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,060,000.00	18,219,130.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	532,552,888.00	615,623,420.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	51,590,188.00	27,408,120.00
131103	ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,848,400.00	4,915,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,741,788.00	22,492,720.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	480,962,700.00	588,215,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	480,962,700.00	588,215,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	518,017,688.00	568,526,650.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	518,017,688.00	568,526,650.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	498,840,839.00	545,031,532.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	231,936,622.00	249,683,847.83
210101	Үндсэн цалин	150,509,853.00	192,143,889.83
210102	Нэмэгдэл	42,410,092.00	44,392,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	39,016,677.00	13,147,358.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,845,629.00	30,350,336.83
210201	Тэтгэврийн даатгал	20,671,723.44	20,675,348.04
210202	Тэтгэмжийн даатгал	2,293,474.64	2,468,139.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,834,778.74	1,982,597.28
210204	Ажилгүйдлийн даатгал	458,694.90	487,341.20
210205	Эрүүл мэндийн даатгал	4,586,957.28	4,736,910.54

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	93,589,900.00	99,734,400.30
210301	Гэрэл, цахилгаан	16,621,900.00	22,766,400.30
210302	Түлш, халаалт	76,368,000.00	76,368,000.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,372,000.00	36,513,899.73
210401	Бичиг хэрэг	2,323,000.00	3,098,000.00
210402	Тээвэр, шатахуун	17,018,500.00	25,488,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,530,500.00	2,426,999.73
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000.00	5,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	500,000.00
2105	Нормативт зардал	500,000.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,976,900.00	50,275,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	573,200.00	1,720,000.00
210604	Урсгал засвар	23,403,700.00	48,555,700.00
2107	Томилолт, зочны зардал	2,582,000.00	4,849,400.00
210702	Дотоод албан томилолт	2,582,000.00	4,849,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	735,500.00	735,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	374,400.00	374,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	361,100.00	361,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	90,302,288.00	72,088,448.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	89,402,288.00	71,088,448.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	900,000.00	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,176,849.00	23,495,117.31
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	2,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,176,849.00	20,995,117.31
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,176,849.00	20,995,117.31
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	15,595,200.00	65,315,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	12,926,800.00	67,984,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,926,800.00	67,984,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	12,926,800.00	67,984,300.00
220001	Барилга байгууламж	-	35,000,000.00
222001	Тоног төхөөрөмж	10,826,800.00	32,984,300.00
223001	Бусад хөрөнгө	2,100,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(12,926,800.00)	(67,984,300.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	2,668,400.00	(2,668,400.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,668,400.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,668,400.00	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	467,647,997.17	884,776,777.26	350,683,471.35	1,703,108,245.78
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	467,647,997.17	884,776,777.26	350,683,471.35	1,703,108,245.78
3	Тайлант үеийн үр дүн	-	-	(81,068,658.92)	(81,068,658.92)
4	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	467,647,997.17	884,776,777.26	269,614,812.43	1,622,039,586.86
5	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	467,647,997.17	884,776,777.26	269,614,812.43	1,622,039,586.86
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	467,647,997.17	884,776,777.26	269,614,812.43	1,622,039,586.86
7	Тайлант үеийн үр дүн	-	-	209,587,268.08	209,587,268.08
8	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	467,647,997.17	884,776,777.26	479,202,080.51	1,831,626,854.94

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	602,035,200.00	585,439,312.69	16,595,887.31	97.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	602,035,200.00	585,439,312.69	16,595,887.31	97.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	599,535,200.00	582,939,312.69	16,595,887.31	97.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	258,454,900.00	249,683,847.83	8,771,052.17	96.6
210101	Үндсэн цалин	163,943,200.00	192,143,889.83	(28,200,689.83)	117.2
210102	Нэмэгдэл	40,392,100.00	44,392,600.00	(4,000,500.00)	109.9
210105	Гэрээт ажлын хөлс	54,119,600.00	13,147,358.00	40,972,242.00	24.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,306,800.00	30,350,336.83	1,956,463.17	93.9
210201	Тэтгэврийн даатгал	21,968,600.00	20,675,348.04	1,293,251.96	94.1
210202	Тэтгэмжийн даатгал	2,067,600.00	2,468,139.77	(400,539.77)	119.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,584,600.00	1,982,597.28	602,002.72	76.7
210204	Ажилгүйдлийн даатгал	516,900.00	487,341.20	29,558.80	94.3
210205	Эрүүл мэндийн даатгал	5,169,100.00	4,736,910.54	432,189.46	91.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	99,589,900.00	97,066,000.30	2,523,899.70	97.5
210301	Гэрэл, цахилгаан	22,621,900.00	20,098,000.30	2,523,899.70	88.8
210302	Түлш, халаалт	76,368,000.00	76,368,000.00	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	600,000.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	34,818,100.00	34,800,299.73	17,800.27	99.9
210401	Бичиг хэрэг	3,098,000.00	3,098,000.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	23,775,300.00	23,775,300.00	-	100.0

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,444,800.00	2,426,999.73	17,800.27	99.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	500,000.00	-	100.0
2105	Нормативт зардал	800,000.00	800,000.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	118,260,000.00	118,260,000.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	33,000,000.00	33,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	85,260,000.00	85,260,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	8,070,000.00	4,849,400.00	3,220,600.00	60.1
210702	Дотоод албан томилолт	8,070,000.00	4,849,400.00	3,220,600.00	60.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	735,500.00	735,500.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	374,400.00	374,400.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	361,100.00	361,100.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,500,000.00	46,393,928.00	106,072.00	99.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,500,000.00	45,393,928.00	106,072.00	99.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,500,000.00	2,500,000.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,500,000.00	2,500,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000.00	2,500,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	602,035,300.00	606,434,430.00	(4,399,130.00)	100.7
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	588,215,300.00	588,215,300.00	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	588,215,300.00	588,215,300.00	-	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	13,820,000.00	18,219,130.00	(4,399,130.00)	131.8
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,820,000.00	18,219,130.00	(4,399,130.00)	131.8
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
620001	Удирдах ажилтан	7	7	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	10	10	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	8	8	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ			-	
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8	8	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11	11	-	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6	6	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
-----	----------	-----------

I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	30,076,520.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	30,076,520.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,076,520.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,668,400.00
210301	Гэрэл, цахилгаан	2,668,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,713,600.00
210402	Тээвэр, шатахуун	1,713,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,694,520.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,694,520.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	30,076,520.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,076,520.00
131103	ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,915,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,492,720.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,668,400.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Рашаант сумын Засаг даргын тамгын газар эрхэм зорилгоо “МУ-ын ЗГ-ын болон аймаг сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх” гэж тодорхойлжээ.

2022 онд “Эрч хүчтэй, бүтээлч сэтгэлгээтэй шинийг эрэлхийлсэн, чадварлаг эвсэг хам олон хөгжлийн хөтөч уриатай мэдлэг чадварт суурилсан, мэргэшсэн захиргааны байгууллага болох” зорилтыг дэвшүүлэн, үйл ажиллагааны чиглэлээ дараа байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хууль тогтоомж, хөгжлийн бодлого, стратеги зорилт, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, хяналт тавих,
- Төрийн албаны хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж мэргэшсэн тогтвортой чадварлаг төрийн албыг бий болгох
- Байгууллагын төсвийг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнах, хяналт тавих ажлыг сайжруулж төсвийн тэнцлийг хангаж ажиллах,
- Батлах хамгаалах болон гамшгаас хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах,
- Хууль, эрх зүй, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг шуурхай зохион байгуулж, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх,
- Хэвлэл мэдээллийн ажлыг шинэ шатанд гаргаж иргэдэд үнэн зөв мэдээллийг цаг хугацаанд нь шуурхай хүргэж ажиллах,
- Аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам”, сумын Засаг даргын “Рашаант-Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай, шилэн дансны тухай, Татварын багц, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон түүнийг дагалдаж гарсан тогтоол, дүрэм журам, эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрүүдийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Рашаант сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Рашаант сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дугаар захирамжаар баталсан бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. 2022 онд бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 209,289.3 мянган төгрөгөөр буюу 12.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,668.40	-	(2,668.40)
Авлага	-	1,447.57	1,447.57
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	36,898.02	54,177.26	17,279.24
Үндсэн хөрөнгө	1,582,771.13	1,776,002.02	193,230.90
Нийт хөрөнгө	1,622,337.55	1,831,626.85	209,289.31
Өр төлбөр	297.96	-	(297.96)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,622,039.59	1,831,626.85	209,587.27
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,622,337.55	1,831,626.85	209,289.31

Дээрх хүснэгтээс харахад тайлант онд материаллаг өөрчлөлт гарсан данс нь бараа материал, үндсэн хөрөнгийн дансууд өссөн байна.

Засаг даргын тамгын газрын их засвартай холбоотой тохижилтод 29 нэр төрлийн 17,279.2 мянган төгрөгийн аж ахуйн материалын худалдан авалт хийгдсэн байна.

Өргөтгөлийн засварт 35,000.0 мянга, 8 нэр төрлийн 28,759.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг төсвийн хөрөнгөөр бэлтгэж, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 85 нэр төрлийн 260,618.1 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, газар, бусад үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэл тайланд тусгасан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 476,955.7 мянга, өөрийн орлогоос 1,060.0 мянган төгрөг нийт 478,015.7 мянган төгрөгийг бүрдүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаар зардлыг 476,955.7 мянган төгрөгөөр, өөрийн орлогоос 1,060.0 мянган төгрөг нийт 478,015.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд 1 удаа тодотгол хийгдэж, тоног төхөөрөмж 18,000.0 мянга, урсгал засварын зардал 16,260.0 мянга, шатахууны зардал 5,500.0 мянга, цалингийн зардал 61,119.6 мянга, НДШ-ийн зардал 7,640.0 мянга, албан томилолтын зардал 2,500.0 мянга, бараа үйлчилгээний зардал 500.0 мянга, баяр наадмын зардлыг 1,000.0 мянган төгрөгөөр нийт 124,019.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр өөрийн орлого 13,820.0 мянга, орон нутгийн төсвөөс 588,215.3 мянган төгрөг нийт 602,035.3 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 588,215.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, 13,820.0 мянган төгрөгийн өөрийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 581,039.9 мянган төгрөг буюу 96.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 20,995.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/Д	Хөтөлбөр арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Хөтөлбөр арга хэмжээ				
Нийт дүн			602,035.3	581,039.9	20,995.1	96.4
1	70105	80101	459,431.7	439,232.7	20,198.8	95.5
2		80106	52,341.7	51,651.7	690.0	98.6
3		80112	38,761.9	38,761.6	0.3	99.9
4		80802	2,500.0	2,500.0	-	100.0
5		81102	39,000.0	38,893.9	106.0	100.0
6		82212	5,000.0	5,000.0	-	99.7
7		82801	5,000.0	5,000.0	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 30076,5 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч эдийн засгийн ангиллын дагуу зарцуулалтын эрх нээлгэн зарцуулсан байна. Нэмэлт орлогын эх үүсвэрийг хүснэгтээр харуулав.

/мянган төгрөгөөр/

№	Эх үүсвэр	Мөнгөн дүн
1	Булган мээж ОНӨХХК /төрөөс хариуцах төлөх цэвэр усны төлбөр/	6,083.8
2	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас /бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх зардал/	15,678.1
3	Статистикийн хэлтсээс хөдөө аж ахуйн болон хагас жилийн мал тооллого, багийн засаг дарга нарт тооллогын урамшуулалд	3,814.6
4	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас цэвэр орчин цэмцгэр булган аяны зардалд	2,000.0
5	Өвөрхангай аймгийн байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд	2,500.0
Нийт дүн		30,076.5

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Рашаант сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Рашаант сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03/24 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвөөс 602,035.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 9,030.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг

төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,772.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Хуулийн 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой зардлуудыг санхүүжүүлээгүй байна. Хуулийн 20 дугаар зүйлийн тайлагнал, ил тод байдлын 20.5 -д заасан этгээд шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуульд заасан нийт 152 мэдээлэл мэдээлэхээс хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 03/156, 03/157, Б/13 дугаар албан тоотоор тус тус ирүүлсэн.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь

Төлбөрийн акт	1	296.3	1	296.3	100.0
Албан шаардлага	7	234,917.2	7	234,917.2	100.0
Зөвлөмж	2	57,338.5	2	57,338.5	100.0
Нийт дүн	10	294,952.0	10	294,952.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын гүйцэтгэх цаг хугацааны нөөц, цар хүрээ хязгаарлагдмал байсан учраас дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдэлд бүрэн тооллогын горим сорил хэрэгжүүлэн, өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, 2022 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын тайланд дурдсан зүйлсийг шийдвэрлэсэн байдал зэргийг тусгайлан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 43,495.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 43,495.8 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- Цалингийн зардлыг тооцоолсон цалингаар тооцооны дансаар дамжуулаагүй, НДШ, ХХОАТ, бусад өглөгийг шууд зардлаар бүртгэснийг залруулсан.

Аудитаар нийт 31,405.5 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 31,405.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүллээ.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

5.2 Албан шаардлага

1. Түшээт булаг ХХК-иас шатахууныг бичгээр худалдан авалт хийдэг гэх боловч и-баримтаар баталгаажуулаагүй, зарлагын баримт байхгүй, шатахуун зарцуулалтад жолоочийн тооцооны хуудас бодоогүй, ажил гүйцэтгэх гэрээ байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил үйлгээг, бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ыг баримтлаагүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжийг хэрэгжүүлэн батлагдсан төсвийг зориулалтын дагуу анхан шатны баримтын бүрдлийг хангуулан зарцуулж, алдаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгөх.

5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй болно.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 01/88

Булган сум

А0640253

ЗЧА-2023/02/21А-ЛТА-ТМЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Рашаант сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Түшээт булаг ХХК-иас 31,405,450.00 (гучин нэгэн сая дөрвөн зуун таван мянга дөрвөн зуун тавь) төгрөгийн шатахууныг бичгээр худалдан авалт хийдэг гэх боловч и-баримтаар баталгаажуулаагүй, зарлагын баримт байхгүй, шатахуун зарцуулалтад жолоочийн тооцооны хуудас бодоогүй, ажил гүйцэтгэх гэрээ байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил үйлгээг, бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ыг баримтлаагүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэн батлагдсан төсвийг зориулалтын дагуу анхан шатны баримтын бүрдлийг хангуулан зарцуулж, алдаа зөрчлийг таслан зогсоож биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 10-ны дотор Төрийн аудитын газарт нотлох баримтын хамт ирүүлэх.
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Рашаант сумын сумын Засаг даргын тамгын газрын дарга (Б.Чүлтэмсүрэн), нягтлан бодогч (Ц.Энхбаяр) нарт даалгав.

006040274

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Б.ЭРДЭНЭ
Ж.ЭНХЦООДОЛ
Г.ЦЭРЭНЛХАМ

